



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/464

Улаанбаатар хот

**«Хан-Уул дүүргийн Дотоод аудитын албаны
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 1,580,000 (нэг сая таван зуун наян мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн Дотоод аудитын алба (О.Одгэрэл)-нд зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 2 нэр төрлийн нийт 1,580,000 (нэг сая таван зуун наян мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгахыг Хан-Уул дүүргийн Дотоод аудитын алба (О.Одгэрэл)-нд үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050001257



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 03 -ны өдрийн А/464 дугаар тушаалын хавсралт

Актлах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн Дотоод аудитын алба

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	ЭБХХХ комиссын хурлын шийдвэр
1	Санхүүгийн тооцоолох програм	6	ш	1	810,000.00	810,000.00	810,000.00	-	Хугацаа дууссан	актлах	устгах
2	Байгууллагын вэб сайт	6	ш	1	770,000.00	770,000.00	770,000.00	-	Хугацаа дууссан	актлах	устгах
Нийт хөрөнгийн дүн						1,580,000.00	1,580,000.00				
Үүнээс: Худалдах хөрөнгө						-	-				
Устгах хөрөнгө						1,580,000.00					
Татан төвлөрүүлэх хөрөнгө						-	-				
Худалдсанаас олох орлого						-	-				
НӨАУГ-т төвлөрүүлэх (30%/)						-	-				